Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга
Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 20 агентлаг, 18 сумын Засаг даргын Тамгын газарт ёс зүйн дэд хороод төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
Аймгийн Засаг даргын 2025 оны А/144 захирамжаар шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх, үйл ажиллагаанд дадлагажуулах хөтөлбөр батлууллаа. Хөтөлбөрийн хүрээнд шинээр ажилд томилогдсон 9 байгууллагын 17 албан хаагчид “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, Төрийн албаны ёс зүйн дэд хорооны ажиллах журам, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмаар сургалт зохион байгуулж ажиллалаа. Аймгийн Засаг даргын Тамгын газраас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хэм хэмжээний талаар гарын авлага бэлтгэж тараасан нь өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж байна. Төрийн албаны стандартыг бүх сум, агентлагт албан бичгээр хүргүүлэн, төрийн албан хаагчдаар судлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран Дарив, Шарга, Хөхморьт, Цээл сумдын “Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн”-д оролцож, “Төрийн албаны стандарт”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сэдвээр сургалт мэдээлэл хийж нийт 450 гаруй төрийн албан хаагч хамрагдсан. Авлигын эсрэг уриалсан видео контентыг бүтээж Миний Алтай сошиал ТВ, Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас, Сүбээдэй.mn сайт, UBS телевиз зэрэг олон нийтийн сувгуудаар иргэд, олон нийтэд сурталчилж ажиллалаа. Аймаг, сумын нийт 32 төрийн байгууллага авлигын эсрэг аянд нэгдэж авлигын эсрэг уриалсан 32 видео контентыг бүтээж олон нийтэд түгээсэн нь үр дүнтэй ажил болсон.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал
Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн дагуу холбогдох албан тушаалд нэр дэвшсэн 145 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим системд бүртгэн авлигатай тэмцэх газарт хүргүүлж шаардлага хангасан иргэдийг томиллоо. Авлигатай тэмцэх газраас зөвшөөрсөн хариу ирсэн үед иргэнийг албан тушаалд томилох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг чиглэлийг тухай бүр сум, агентлагуудад хүргүүлэн аймгийн хэмжээнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийг хэрэгжүүлж ажиллалаа. Энэ онд ёс зүйн зөрчил гаргасан удирдах албан тушаалтан байхгүй байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа
Байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах зорилгоор Нутгийн хөгжил, бидний зүтгэл төрийн бус байгууллагатай хамтран хувь хүний хөгжлийн чиглэлээр 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 95 албан хаагч хамрагдлаа.

Мөн байгууллагын түвшинд “Алагчлаагүй оролцоо”-г хангах буюу хэнийг ч орхигдуулахгүй, ялгаварлан гадуурхахгүй, оролцоог тэгш хангах, үе хоорондын тэгш байдлыг дэмжих сэтгэлгээг төлөвшүүлэх зорилготой “Сэтгэлгээний өөрчлөлт” сэдэвт сургалтыг 12 байгууллагын 51 албан хаагчдад зохион байгууллаа. Ёс зүйн дэд хороод байгууллагын түвшинд зөрчил үүсч болзошгүй шалтгаан нөхцлийг тодорхойлоход 90 хувьд нь ил тод байдал, хариуцлага, харилцаа, ашиг сонирхлын зөрчлөөс шалтгаалах магадлалтай байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн хэм хэмжээний талаар нийт 42 байгууллагын давхардсан тоогоор 3216 төрийн албан хаагчид сургалт зохион байгууллаа. Энэ онд 4 байгууллагын 7 албан хаагч ёс зүйн зөрчил гаргасныг тухай бүр хуулийн дагуу шийдвэрлэн ажиллалаа.

Гарсан үр дүн, ололт амжилт	Бэрхшээл
Тухайн онд ёс зүйн зөрчил, сахилгын шийтгэл ногдуулсан удирдах албан тушаалтан байхгүй.	Бэрхшээл байгаагүй.

Санал

1. Төрийн албаны салбар зөвлөлийн болон ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшуулал төсөвт байхгүй учир давхар ажил хариуцуулан, хариуцлага тооцоход хүндрэлтэй байна.
2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Төрийн албаны зөвлөлөөс анхаарах.
3. Даргын манлайлалыг үнэлэх шалгуур, аргачлал батлах.
4. Ёс зүйн чиглэлээр багц цагийн сургалтын мэдээлэл дутмаг, тодорхойгүй байна.

БАТАЛГААЖУУЛАЛТ:
ТОМИЛОХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН
ДАРГА Ш.ЭРДЭНЭБАТ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА,
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Я.ЖАРГАЛЦЭЦЭГ
НЭГТГЭСЭН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
МЭРГЭЖИЛТЭН Ч.НЯНДАГ

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Я.ЖАРГАЛЦЭЦЭГ
2025 оны 04 дугаар сарын 21 өдөр

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.04.21

Алтай хот

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хугацаа /улирлаар/	Хариуцах албан тушаалтан
1	Байгууллагын албан хаагчдад болон төрийн албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Сургалтын тоо	-	2	II-IV	Ёс зүйн дэд хороо
2	Шинээр ажилд орсон албан хаагчдад ёс зүйн талаар сургалт зохион байгуулахад холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах	Шинээр томилогдсон албан хаагч бүрт хийгдсэн сургалтын тоо	-	Тухай бүр	II-IV	Ёс зүйн дэд хороо
3	Байгууллага дотор үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх	Дүн шинжилгээний санал зөвлөмжийн тоо	-	1-ээс доошгүй	IV	Ёс зүйн дэд хороо
4	Ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээллийг хүлээн авч цахим системд бүртгэх.	Бүртгэсэн мэдээллийн тоо	-	Тухай бүр	II-IV	Ч.Няндаг
5	Ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шийдвэрлэж дүгнэлт гаргах	Шийдвэрлэлтийн хувь	-	100	II-IV	Ёс зүйн дэд хороо
6	Байгууллагын вэб сайтад ёс зүйн хорооны ажлын мэдээллийг тухай бүр байршуулах.	Байршуулсан мэдээний тоо	-	4	II-IV	Ч.Няндаг
7	Бусад байгууллагын ёс зүйн дэд хороотой харилцан туршлага солилцох, сум, байгуулагуудад ажиллах	Хамтран ажилласан байгууллагын тоо		3-аас доошгүй	II-IV	Ёс зүйн дэд хороо

8	Батлагдсан загварын дагуу дүгнэлтийн бланк хэвлүүлэх.	Хэвлүүлсэн бланкны тоо	-	20	II	Я.Жаргалцэцэг
9	Ёс зүйн дэд хорооны ажлын тайлан мэдээг Ёс зүйн хороонд хүргүүлэх	Хүргүүлсэн тайлангийн тоо	-	1	2026 оны 1 сард	Ч.Няндаг
10	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хэм хэмжээний мэдээлэл агуулсан гарын авлага бэлтгэж албан хаагчдад хүргүүлэх	Гарын авлага бэлтгэж өгсөн албан хаагчийн тоо		40-өөс доошгүй	II-IV	Ёс зүйн дэд хороо

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН

МЭРГЭЖИЛТЭН Ч.НЯНДАГ